



ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 01 сарын 06 өдөр

Дугаар 01

Өмнөдэлгэр сум

Сумын Засаг даргын 2024-2028 оны
үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.4 дэх заалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11, 9.11.1 дэх заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Дөрөвдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2.Сумын Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, жил бүр биелэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдаанд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга (Р.Энхтөр)-д даалгасугай.


3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хороодод үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ПҮРЭВДОРЖ

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны ᠒/дүгээр сарын ᠒᠘-ны өдрийн
Дөрөвдүгээр хуралдааны ᠒/дүгээр
тогтоолын хавсралт



ХЭНТИЙ АЙМГИЙН ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 9 дэх удаагийн сонгуулийн үр дүнгээр шинээр томилогдсон сумын Засаг дарга Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Монгол улсын хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэхэд чиглэн нутгийн иргэдийн санал санаачлагад үндэслэн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрөө тодорхойлж байна.

Сумын Засаг дарга үйл ажиллагааны хөтөлбөрөө боловсруулахдаа айл өрхийн орлогыг нэмэгдүүлж, чинээлэг, хангалуун амьдрах боломжийг бий болгох, амьдралын чанарыг дээшлүүлэх, ажилтай орлоготой, амьдарлын зөв хэвшилтэй, ёс зүйтэй иргэдээ эрүүл, аюулгүй орчинд ажиллаж амьдрах боломж, нөхцлийг бүрдүүлэх байгаль орчинд ээлтэй, ногоон хөгжилд суурилсан тогтвортой хөгжлийн бодлого зорилтыг хэрэгжүүлэхэд онцгой анхаарч дараах 5 багц асуудлуудын хүрээнд хэрэгжүүлэх зорилго, зорилтуудаа тодорхойллоо.

НЭГ. ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ

1.1.ГЭР БҮЛ, ХҮҮХЭД ХАМГААЛАЛ, ХҮН АМ

1.1.1. Гэр бүл болон нийгмийн орчин дахь хүүхэд хамгааллыг сайжруулж, өсвөр үе, залуучуудын нийгмийн оролцоог нэмэгдүүлнэ.

1.1.1.1. Хүүхэд хамгааллыг сайжруулах, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, өрх, гэр бүлийн хөгжлийг дэмжсэн бодлого хэрэгжүүлнэ.

1.1.1.2. Стандартын шаардлага хангасан хүүхдийн тоглоомын талбайг 3 газарт шинээр байгуулж, засварлаж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.1.1.3. Суманд үйл ажиллагаа явуулдаг нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж, хүүхэд, эмэгтэйчүүд, залуучууд, ахмадууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн зорилтот бүлгүүдийг дэмжиж ажиллана.

1.1.1.5. Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын "Өмнөдэлгэрийн ирээдүйн эзэд" хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.

1.2.БОЛОВСРОЛ

1.2.1. Хүүхэд бүрийн ялгаатай хэрэгцээнд тулгуурлан тэгш хүртээмжтэй оролцоог дэмжин сургалтын орчныг сайжруулж, сургалтын чанарыг дээшлүүлнэ.

1.2.1.1. Хүүхэд багачуудын сурч, хөгжих орчныг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.

1.2.1.2. Багш нарын мэргэшил, чадавхыг сайжруулна

1.2.1.3. Боловсролын салбарын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан орчныг бүрдүүлнэ.

1.2.1.4. Дотуур байрны хүүхдийн ая тухтай амьдрах боломжийг нэмэгдүүлнэ.

1.2.1.5. Дэвшилтэд технологийг ашиглаж цахим сургалтын орчныг нэмэгдүүлнэ.

1.2.1.6. ЕБС, дотуур байр, СӨБ-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

1.2.1.7. Сургууль, сумын номын санд цахим номын сан бий болгох, номын фондод сургуулийн хүүхдүүдийн заавал судлах уран зохиолын номоор баяжилт хийх

1.2.1.8. Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдүүдийн сурах орчныг бүрдүүлж ТХБ-ын өрөөг орчин үеийн шаардлагад нийцүүлэн бий болгоно.

1.2.1.9. Дээд боловсрол эзэмшиж байгаа залуучуудтай гэрээ байгуулах замаар орон нутагтаа шаардлагатай мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэнэ.

1.2.1.10. Хүүхэд бүрийг хөгжүүлж, бүтээлч сэтгэлгээтэй, нутаг орныхоо байгаль, түүх, соёл, уламжлалаараа бахархдаг “Зөв Монгол хүүхэд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.2.1.11. 1-5-р ангийн сурагчдад “Сүү” хөтөлбөрийг хэрэгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

1.3.ЭРҮҮЛ МЭНД

1.3.1. Нийгмийн эрүүл мэндийн болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

1.3.1.1. Эрүүл мэндийн хэв маяг, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийг дэмжих чиглэлээр иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, зонхилон тохиолдох өвчнөөс сэргийлнэ.

- 1.3.1.2. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг боловсрол, ур чадварыг дээшлүүлэх, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулна
- 1.3.1.3. Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлнэ.
- 1.3.1.4. Эрүүл мэндийн төвд шаардлагатай тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх, сайжруулах.
- 1.3.1.5. Эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжиж, сэргийлж болох хүүхдийн эндэгдлийг бууруулна.
- 1.3.1.6. Эрүүл шүд арга хэмжээг зохион байгуулна .
- 1.3.1.7. Зорилтот насны иргэдэд хеликобактерийн оношлогоог хийж өвчлөлийг бууруулна.
- 1.3.1.8. Хүн амын 70 хувийг эрдэс бодисын / Д, кальци / оношлогоонд хамруулж эмчлэх .
- 1.3.1.9. “Элэг бүтэн монгол “ хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.3.1.10. Элгэний В вирусын эсрэг сайн дурын дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлнэ .
- 1.3.1.11. Эх хүүхдийн гурвалсан хяналтыг сайжруулах
- 1.3.1.12. 0-18 насны хүүхдүүдийг эрт илрүүлэгийн үзлэгт хамруулах.
- 1.3.1.13. Сүрьеэ, БЗДХалдварын эрт илрүүлэлтийг эрчимжүүлэн эмчилгээний хамрагдалтыг 90 % доошгүй хувьд хүргэнэ.

1.4.СОЁЛ, УРЛАГ

- 1.4.1. Хүн амд соёлын боловсрол олгох, орон нутгийн онцлог бүхий соёлын бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлнэ.
- 1.4.1.1. Соёл урлагийн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 1.4.1.2. Соёлын ажилтнуудын мэргэжил, ур чадварыг дээшлүүлнэ.
- 1.4.1.3. Соёлын биет ба биет бус өвийг бүртгэлжүүлэх, судлах, хадгалж, хамгаалах, өвлөн уламжлуулах ажлыг зохион байгуулна.
- 1.4.1.4. Соёлын төвийн барилгыг засварлуулах, хөгжим, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлнэ.

1.5.БИЕИЙН ТАМИР, СПОРТ

- 1.5.1. Биеийн тамир спортын хүртээмжийг сайжруулж, иргэдийн бие бялдарын хөгжлийг дээшлүүлнэ.
- 1.5.1.1. Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, эрүүл идэвхитэй амьдрах дадлыг бий болгох, нийтийн биеийн тамирыг хөгжүүлнэ.

- 1.5.1.2. Монгол үндэсний спорт, уламжлалт тоглоом наадгайг сэргээн хөгжүүлэхэд анхаарч, дэмжиж ажиллана. /Үндэсний спорт болон их спортын наадам, тэмцээн уралдаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэн сумаа төлөөлөн улсын чанартай спортын наадмуудад оролцогчдод дэмжлэг үзүүлэх/
- 1.5.1.3. Спортын төрлүүдээр сумын аварга шалгаруулах тэмцээнүүдийг жил бүр зохион байгуулна. Жилд 1-2 удаа аймаг, улсын чанартай уралдаан тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулна.
- 1.5.1.4. Олон улс, улс, аймаг бүсийн уралдаан тэмцээнд оролцох тамирчдад дэмжлэг үзүүлнэ.
- 1.5.1.5. Сумандаа хөгжиж буй спортын төрлүүдээр өсвөрийн шигшээ багуудад дэмжлэг үзүүлэх. Орон нутагт шинээр хөгжиж байгаа спортын төрлүүдээр хичээллэгсдэд дэмжлэг үзүүлэх /дартс, үндэсний сур, шатар, даам, модон барилдаан, шагай гм/

1.6.ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАЛАМЖ, НИЙГМИЙН ДААТГАЛ

- 1.6.1. Халамжаас хөдөлмөрт шилжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.
 - 1.6.1.1. Жижиг дунд үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулж өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилго бүхий хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана.
 - 1.6.1.2. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажилгүй иргэн, даатгуулагчдад нийгмийн даатгалын үйлчилгээг хүртээмжтэй үзүүлнэ.
 - 1.6.1.3. Ажил хайгч, ажилгүй иргэнийг ажилд зуучилж хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.
 - 1.6.1.4. Төсөл хөтөлбөрүүдээр дамжуулан байнгын болон түр ажлын байрыг нэмэгдүүлнэ.
 - 1.6.1.5. Нийгмийн халамжийн зорилтот өрхийн хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэдийг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамруулна.
 - 1.6.1.6. Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлнэ.
 - 1.6.1.7. Сайн дурын даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлнэ.
 - 1.6.1.8. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажилгүй иргэн, даатгуулагчдад нийгмийн даатгалын үйлчилгээг чанартай, хүртээмжтэй үзүүлнэ.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ

Төсөв, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулан, төр, хувийн хэвшлийн түншлэлийн эдийн засгийг бэхжүүлнэ. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох орон нутгийн чадавхыг сайжруулна.

2.1. ТӨСӨВ САНХҮҮ

2.1.1. Төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсвийн ил тод байдлыг хангаж ажиллана.

2.1.1.1. Хоршоог хөгжүүлэх сангийн зээлийн хэрэгжилтэнд хяналт тавьж, эргэн төлөлтийг сайжруулж, жижиг дунд бичил бизнесийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.1.1.2. Төсөв байгууллагуудын төсвийн ил, тод байдлыг хангаж, дотоод хяналт шалгалтыг сайжруулж, санхүүгийн үйл ажиллагааны зөрчлийг бууруулна.

2.1.1.3. Шилэн дансны цахим хуудсаар байгууллагын төсвийн ил тод байдлыг хангаж ажиллана.

2.1.1.4. Цахим татварын системийн ашиглалтыг нэмэгдүүлнэ.

2.1.1.5. Орон нутгийн өмч хөрөнгийн бүртгэл хяналтыг сайжруулна.

2.2. ОРОН СУУЦ, ДЭД БҮТЭЦ

2.2.1. Иргэдийн амьдрах ая тухтай орчныг бүрдүүлнэ.

2.2.1.1. Хот суурин газрын хөгжлийн төлөвлөгөөг шинээр боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.

2.2.1.2. Суманд орчин үеийн, төвлөрсөн дулаан цэвэр ус, бохир усны системд бүрэн холбогдсон орон сууцыг барьж, орон сууцны хөнгөлөлттэй зээлд иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулна.

2.2.1.3. Эрчим хүчний хэмнэлттэй, байгальд ээлтэй эрчим хүчний хэмнэлттэй, ногоон барилга байгууламжийн шаардлага хангасан барилгын тоог нэмэгдүүлж, нийтийн болон амины орон сууц барих санаачилгыг дэмжинэ.

2.2.1.4. Инженерийн шугам сүлжээний төсөл арга хэмжээнүүдийг ашиглалтад оруулж, албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхүүдийг холбох ажлыг зохион байгуулж, найдвартай ажиллагааг хангана.

2.2.1.5. Үерийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийж, ус зайлуулах шугам сүлжээг байгуулна.

2.2.1.6. Хөдөөний багуудад үүрэн телефоны сүлжээний өргөтгөл, сайжруулалтыг хийж гүйцэтгэнэ.

2.2.1.7. Эгнээ гудамж болон засмал замын дагуу гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх.

2.2.1.8. Үйлдвэрлэл, үйлчилгээний шилдэг салбаруудтай түншлэл,

хамтын ажиллагааг өргөжүүлж орон нутагт шаардлагатай салбаруудыг нээж ажиллуулах.

- 2.2.1.9. Орон нутгийн чанартай гүүрийг засварлах, шинээр барих, сумын төвийн эгнээ гудамжны хотгор гүдгэрийг тэгшилнэ.

2.3. АЯЛАЛ ЖУУЛЧАЛ

- 2.3.1. Аялал жуулчлалыг хөгжүүлж, орон нутаг, өв соёлоо сурталчлан өрхийн орлого нэмэгдүүлнэ.

- 2.3.2. "Хэнтий аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх 2030" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана.

- 2.3.3 Түүхийн дурсгалт газруудыг судлан таниулах.

ГУРАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙ

3.1. МАЛ АЖ АХУЙ

- 3.1.1. Уламжлалт бэлчээрийн аж ахуйг зонхилон хагас эрчимжсэн аж ахуйг дэмжиж, үр ашгийг нэмэгдүүлнэ.

- 3.1.1.1. Бэлчээрийн менежментийг сайжруулах бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

- 3.1.1.2. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийг дэмжиж малын тоог чанарт шилжүүлж, бэлчээр ашиглалтыг сайжруулна.

- 3.1.1.3. Бүс нутгийн онцлогт тохирсон эрчимжсэн мал аж ахуйг дэмжиж, баталгаажсан үүлдэр, омгийн малын ашиг шимийг нэмэгдүүлнэ.

- 3.1.1.4. Мал эмнэлгийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, мал, малын гаралтай хүнсний түүхий эд бүтээгдэхүүний эрүүл, аюулгүй байдлыг хангана.

- 3.1.1.5. Мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, мах, сүүнд анхан шатны шинжилгээ хийх мал эмнэлгийн нэгдсэн төвийг суманд байгуулна.

- 3.1.1.6. Мал, амьтны халдварт өвчний голомт, шимэгчтэх өвчний гаралт, тархалтыг бууруулж, зарим халдварт өвчний байгалийн халдварлалтыг тогтооно.

- 3.1.1.7. Малаас хүнд халдварладаг архаг халдварт бруцеллёз өвчнөөр эрүүл сум, баг, малчин өрхийг баталгаажуулж, эрүүл бүсийг бий болгоно.

- 3.1.1.8. Цөөн малтай малчин, мал бүхий өрхийг дэмжин "Малжуулах" хөтөлбөр хэрэгжүүлнэ.

- 3.1.1.9. Малын гаралтай түүхий эдийн анхан шатны боловсруулалт хийх хоршоодыг нэмэгдүүлэн, дундын хоршоодын үйл ажиллагааг дэмжиж ажиллана.
- 3.1.1.10. "Байгальд ээлтэй малчин" шалгаруулах журмыг сумын ИТХурлаар батлан жил бүр шалгаруулж урамшуулал олгоно.
- 3.1.1.11. Худаг шинээр гаргах, сэргээн засварлах, хөв цөөрөм байгуулах зэргээр бэлчээрийн усан хангамжийг сайжруулах ажлыг зохион байгуулна.

3.2. ГАЗАР ТАРИАЛАН

- 3.2.1. Атрын дөрөвдүгээр аян үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлж ажиллана.
 - 3.2.1.1. "Атар IV" аяны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, "Атар IV" аян, "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлнэ.
 - 3.2.1.2. Иргэд, аж ахуйн нэгж, хөдөө аж ахуйн хоршоо, малчдад үр тариа, малын тэжээлийн ургамал тариалах боломжийг бий болгоно.

3.3. ХҮНС, ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭР

- 3.3.1. Хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлж ажиллана.
 - 3.3.1.1. Хүн ам эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангах, хяналтыг сайжруулах ажлыг хэрэгжүүлнэ.
 - 3.3.1.2. Өрхийн үйлдвэрлэл, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчийг дэмжиж, орон нутгийн бренд бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ.
 - 3.3.1.3. Хүлэмж, зоорийн аж ахуйг жишиг болгон хөгжүүлнэ.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ

- 4.1. Байгалийн унаган төрх, экосистемийн тогтвортой байдлыг хадгалж биологийн олон янз байдлыг хамгаална.
 - 4.1.1. Байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, экосистемийн тэнцвэрт байдлыг хангаж хууль бус ашиглалтад тавих хяналтыг сайжруулна.
 - 4.1.2. Ховор амьтан ургамлыг өсгөн үржүүлж, хамгаалж, нөөцөд тохируулан тогтвортой ашиглана.
 - 4.1.3. Байгалийн нөөцийн хамтын менежментийг хэрэгжүүлж, нөхөрлөл, аж ахуйн олон нийтийн оролцоотой байгаль хамгааллыг сайжруулна.
 - 4.1.4. Ойгоор бүрхэгдсэн талбай, төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлж, ойн нөөцийг хамгаална.

- 4.1.5. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, "Ногоон гудамж", "Иргэн бүр нэг мод" арга хэмжээний хэрэгжилтийг хангана.
- 4.1.6. Ойн хөнөөлт шавжтай тэмцэж ойн хомсдол, доройтол, ой, хээрийн түймрийн эрсдэлийг бууруулна.
- 4.1.7. Уур амьсгалын өөрчлөлт, байгаль, цаг уурын гаралтай гамшигт үзэгдлийг эрт сэрэмжлүүлж, эрсдэлийг бууруулж, дасан зохицох, тэсвэрлэх чадавхыг бэхжүүлнэ.
- 4.1.8. Ойжуулах, ойг цэвэрлэх, нөхөн сэргээх, өнжөөх хамгаалах асуудлыг шийдвэрлэнэ.
- 4.1.9. Гол мөрөн, булаг, шанд, нуур, цөөрмийг хашиж, хамгаалалтад авч байгалийн тэнцвэрт байдлыг хангана.
- 4.1.10. Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлж, орчны бохирдлыг бууруулах, "Цэвэр тохилог Өмнөдэлгэр" хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 4.1.11 Ойн мэргэжлийн байгууллагуудыг чадавхжуулах сургалт, хөтөлбөрт хамруулах, хамгаалалтыг сайжруулахын зэрэгцээ ойн нөхөрлөлүүдийг чадавхжуулах, иргэдийн мод үржүүлгийн аж ахуйг дэмжинэ.

ТАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

5.1. Төрийн цахим шилжилт, үйлчилгээг эрчимжүүлэн, үр ашиг, хүртээмж, ил тод байдлыг нэмэгдүүлэн, чадварлаг төрийн албыг төлөвшүүлж, хүний эрхийг дээдэлсэн, авлигагүй төрийн бодлогыг хэрэгжүүлнэ.

5.1.1. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

- 5.1.1.1. Нийгмийн дэг журам, аюулгүй байдлыг хангаж, нийт гэмт хэргийг хувиар бууруулна.
- 5.1.1.2. Бүх нийтийн эрх зүйн боловсролын хүрээнд хууль тогтоомжийн мэдлэгийг нэмэгдүүлнэ.
- 5.1.1.3. Архины хор хөнөөлөөс урьдчилан сэргийлж "Архидалтгүй Хэнтий" арга хэмжээг зохион байгуулна.
- 5.1.1.4. Төрийн архивын баримтын хадгалалт хамгаалалтын аюулгүй байдлыг хангаж ажиллана.
- 5.1.1.5. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна.
- 5.1.1.6. Иргэдэд үйлчлэх төвтэй болох.

5.2. АВЛИГАГҮЙ НУТГИЙН ЗАХИРГАА

- 5.2.1. "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг орон нутгийн онцлогт тохируулан зохион байгуулна.

- 5.2.2. Төрийн албан хаагчдыг чадавхжуулах, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг сайжруулах, төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлнэ.
- 5.2.3. Мэргэшсэн төрийн албан хаагчдын тоог нэмэгдүүлж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 5.2.4. Төрийн албан хаагчдын хэрэгцээ, шаардлагад үндэслэн "Танхимын болон цахим сургалт"-ын арга хэмжээний хүрээнд төрийн албан хаагчдыг сургалтад хамруулна.
- 5.2.5. "Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөр" хэрэгжүүлнэ.
- 5.2.6. Төрийн албан хаагчдыг улс төрөөс ангид тогтвортой ажиллах орчин нөхцлийг бүрдүүлнэ.
- 5.2.7. Орон нутгийн засаглалд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх "Иргэдийн оролцоот-Нэг Хэнтий" арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 5.2.8. Иргэдийн хяналт тавих ажиллагааг сайжруулан бодитой, үнэн зөв, тэнцвэртэй мэдээлэл авах, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хангаж, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг ил тод байлгана.

5.3. ЦАХИМ ШИЛЖИЛТ

- 5.3.1. Цахим засаглал төрийн үйлчилгээг ил тод нээлттэйгээр иргэдэд ойртуулах
- 5.3.2. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, төрөөс үзүүлж буй үйлчилгээ болон E-Mongolia системийн уялдааг сайжруулан, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 5.3.3. Төрийн байгууллагад мэдээлэл, харилцаа холбооны технологийн зохистой хэрэглээг нэвтрүүлж, байгууллага хооронд сайн туршлага хуваалцах, сурталчлах арга хэмжээнд хамрагдана.
- 5.3.4. Хэрэглэгчдийн харилцаа холбоо, сүлжээний тасралтгүй найдвартай ажиллагааг хангаж, өндөр хурдны интернэтэд холбогдох боломжийг бүрдүүлнэ.

5.4. ГАДААД БОДЛОГО

- 5.4.1. Гадаад харилцааг өргөжүүлж, гадаад орны төрийн болон төрийн бус байгууллагуудтай холбоо тогтоож, төсөл хөтөлбөртэй хамтран ажиллана.

5.5. ГАМШГИЙН ҮЕИЙН БЭЛЭН БАЙДАЛ

- 5.5.1. Сумын гамшигтай тэмцэх чадавхыг нэмэгдүүлж, сумын бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлнэ.
- 5.5.2. Гамшгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг чанартай зохион байгуулна.

- 5.5.3. Гамшгийн аюулын үед харилцан ажиллах дадлага, сургуулилтыг нэмэгдүүлэх.
- 5.5.4. Гамшгийн эрсдлийг бууруулах хамтын ажиллагаанд иргэн, хуулийн этгээдийн оролцоог дэмжинэ.
- 5.5.5. Гамшгийн эрсдлээс хамгаалах аюулгүйн фондыг жил бүр нэмэгдүүлнэ.